



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/644

Зуунмод

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар хуралдааны 06 дугаар тогтоолын 6, мөн хуралдааны 08, 09 дүгээр тогтоолын 2 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын үндсэн хууль батлагдсаны 30 жил, Нутгийн өөрөө удирдах байгууллага үүсч хөгжсөний түүхт 30 жилийн ойн Хүндэтгэлийн хуралдаан зохион байгуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.


2. Хүндэтгэлийн хуралдаан зохион байгуулахад шаардагдах 19,100,000 (арван есөн сая нэг зуун мянга) төгрөгийг аймгийн төсвийн хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т, төсвийн ерөнхий нягтлан бодогч (Б.Одончимэг)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР





Аймгийн Засаг даргын 2022 оны 21 дүгээр сарын 10 -ны өдрийн А/644 дүгээр захирамжийн хавсралт



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ БАТЛАГДСАНЫ 30 ЖИЛ,  
НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ШИНЭ ТОГТОЛЦООНЫ 30  
ЖИЛИЙН ОЙН ХҮНДЭТГЭЛИЙН ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХАД  
ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Арга хэмжээ	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Шаардагдах хэмжээ	Нийт үнэ
Хүндэтгэлийн хуралдаан зохион байгуулах	Аймгийн Хүндэт иргэний шагнал	Хүн	3000.000	1	3.000.000
	Лувсандамбийдон мэй 2-р Богдын шагнал	Хүн	1000.000	1	1.000.000
	Үе үеийн хурлын дарга, Засаг дарга, төлөөлөгчдийн гарын бэлэг	Хүн	50.000	17	6.850.000 ! <i>доги</i>
			40.000	150	
Хүндэтгэлийн хуралдаан, бусад арга хэмжээ					8.250.000
Нийт					19.100.000

ТӨСӨВ ХИЙСЭН:  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН  Б.АМАРМЭНД

ТӨСӨВ ХЯНАСАН:  
САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ТӨСВИЙН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  Ч.ЦЭЦЭГСҮРЭН

